

**“БОГД БАНК ХК”-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ
ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ**

Баримт бичгийн нэр:	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
Хувилбарын дугаар:	1.0
Боловсруулсан нэгж:	ТУЗ
Хэрэгжилтэд хяналт тавих:	ТУЗ, дотоод хяналт хариуцсан нэгж

Агуулга

1. Нийтлэг зүйл
2. Журамд гарах зарим нэр томъёоны тодорхойлолт
3. Мэдүүлэг гаргах
4. Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх
5. Бусад зүйл

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1 Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын хүрээнд Хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү журмын зорилго нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, тэдгээрээс компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ Журамд заасан эрх бүхий албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 1.4 Мэдүүлэгч гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц, нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

Хоёр. Журамд гарах зарим нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан гэж компанийн нийт гаргасан хувьцааны 20 болон түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд болон Компанийн тухай хуулийн 84.1, 89.1 мөн компанийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 -д заасны дагуу дараах албан тушаалтанг;

2.1.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

2.1.1.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

2.1.1.3. Гүйцэтгэх захирал, дэд захирал ;

2.1.1.4. Газар, хэлтсийн захирал ;

2.1.1.5. Компани дээр гэрээ, хэлцэл хийх, энэ талаар шийдвэр гаргахад шууд болон шууд бусаар оролцдог бусад албан тушаалтан, ерөнхий нягтлан бодогч эсхүл тухайн чиг үүргийг гүйцэтгэдэг албан тушаалтан ;

2.1.2. Энэ журмын 2.1.1-д заасан эрх бүхий албан тушаалтнуудтай **нэгдмэл сонирхолтой этгээд** гэж тэдгээртэй Компанийн тухай хуулийн 89.2.1, 89.2.2, 89.2.3-т заасан хэлбэрээр холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

2.1.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж энэ журмын 2.1.1, 2.1.2-д заасан этгээдүүдээс компанитай хийх хэлцэлд Компанийн тухай хуулийн 89.1.1 - 89.1.4-д заасан хэлбэрээр оролцсон гэрээ хэлцлийг;

2.1.4. Мэдүүлэг гэж ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх болзошгүй этгээдүүд өөрийн болон өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад Компанийн тухай хуульд заасны дагуу гаргаж өгсөн мэдээллийг;

Гурав. Мэдүүлэг гаргах

- 3.1 Энэхүү журмын 2.1.1-д заасан албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийгдэх талаараа Компанийн тухай хуулийн 91.1.1 - 91.1.4-т заасан мэдээллийг, мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тус тус ТУЗ-ийн нарийн бичгийн даргад уг албан тушаалд томилогдсон, мэдээлэлд өөрчлөлт орсон өдрөөс хойш 10 хоногийн дотор, мэдүүлэх үүрэгтэй.
- 3.2 Энэхүү Журмын 3.1-д заасан мэдүүлгийг үнэн зөвөөр мэдээлээгүй, хугацаа хожимдуулж мэдээлсэн, мэдүүлгт дурьдсан мэдээлэлд өөрчлөлт орсон талаар мэдээлээгүйгээс компанид аливаа хохирол учирсан тохиолдолд буруутай этгээд зохих хариуцлага хүлээж учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.

- 3.3 Мэдүүлгийг бүртгэн хүлээн авч буй албан тушаалтан уг мэдээллийг компанийн гэрээ хэлцэл хийх үед холбогдох этгээдэд мэдээлэх үүрэгтэй.

Дөрөв. Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх.

- 4.1 Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг ердийн журмаар Гүйцэтгэх захирлын хүрээнд шийдэхгүй.
- 4.2 Гүйцэтгэх захирал ийм төрлийн гэрээ, хэлцлийг ТУЗ-д танилцуулан зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр хийнэ. Зөвшөөрөл аваагүй хийгдсэн гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.
- 4.3 Гүйцэтгэх захирлын зөвшөөрөл авах танилцуулгад дараах зүйлийг тусгана. Үүнд:
- 4.3.1 хэлцлийн хүрээнд нийлүүлэх болон худалдан авах зүйлийн нэр, хэмжээ, нийлүүлэх болон худалдан авах хугацаа;
 - 4.3.2 хэлцэлд оролцогч нөгөө талын нэр, компани болон энэ журмын 2.1.1-д заасан этгээдтэй ямар холбоотой болохыг тодорхойлсон тодорхойлолт;
 - 4.3.3 ТУЗ-өөс гарах шийдвэрийн төсөл;
- 4.4 Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх зөвшөөрөл өгөх ТУЗ-ийн шийдвэр нь уг асуудалд сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар гаргана. Хэрэв энд заасан хувиар шийдвэр гарч чадаагүй тохиолдолд уг асуудлыг ХЭХ-д оруулж уг хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхоор шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.
- 4.5 Сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн үнэ нь ижил төрлийн хэлцлийн зах зээл дээрх үнээс доогуур байхыг хориглоно.
- 4.6 Энэ журмын 2.1.1-д заасан этгээд нь өөрийн болон өөртэй нь нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийх хэлцлийг шийдэх ажиллагаанд аливаа байдлаар оролцохыг хориглоно.
- 4.7 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг жилийн тайланд Компанийн тухай хуулийн ...д заасны дагуу тусгах замаар нийтэд мэдээнэ.
- 4.8 Жилийн тайланд сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:
- 4.8.1 хэлцлийн хүрээнд авах болон худалдах зүйлийн нэр, хэмжээ;
 - 4.8.2 хэлцлийн үнэ;
 - 4.8.3 хэлцэлд оролцогч нөгөө талын нэр;
 - 4.8.4 хэлцэлд оролцогч нөгөө талын компани болон компанийн эрх бүхий албан тушаалтантай холбоотой байдал;

Тав. Бусад зүйл

- 5.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компани нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн үр дүнд үүссэн хохирлыг төлүүлэх, уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэдгийг тодорхойлуулах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.
- 5.2. Энэхүү Журамд ТУЗ-ийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд Журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 5.3. Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.

